



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/1409

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны "Аймгийн 2022 оны төсвийн тодотгол батлах тухай" 37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.4-т "Сум бүрт Алтайн брэндийг хөгжүүлж, орон нугийн баялаг бүтээгчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалт, маркетингийг дэмжсэн борлуулалтын төв, интернэт худалдааны сүлжээг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдтэй хамтран бий болгоно." гэсэн зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй "Алтайн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, маркетинг сурталчилгаа"-нд зарцуулагдах 16,000,000.0 (арван зургаан сая) төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

2. Үйл ажиллагаанд зарцуулагдах хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг "Инноваци судалгаа биенес хөгжлийн төв" УТҮГ (Т.Эрхэмбаяр)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

